



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 01/59

Хэрлэн сум

Хурдан морины уралдаан зохион  
байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ, зохион байгуулахыг 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Дурдсан хугацаанд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ зохион байгуулахгүй байхыг иргэд, нийт уяачдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн газар (Д.Батхүү), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Х.Уртнасан), “Сэцэн ханы хүлэг” уяачдын холбоонд тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нар, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Батхүү), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Х.Уртнасан)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

